



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2023/01/НА-СТА-ТТЗ

|   |  |
|---|--|
| Цахим хуудас:<br><a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a><br>Сүхбаатар сум<br>2023 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 7036-3040<br>Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 7036-3036<br>Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a><br>Аудитор: Т.Одсүрэн<br>Утас: 7036-2442<br>Цахим хаяг: <a href="mailto:odsurent@audit.gov.com">odsurent@audit.gov.com</a> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

|  |    |
|--|----|
| <b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b> .....  | 3  |
| <b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....              | 6  |
| <b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....                                | 9  |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....                                    | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....                                    | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                                | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... | 11 |
| 3.5.1 Мөнгөн хөрөнгө .....   | 12 |
| 3.5.2 Авлага .....   | 12 |
| 3.5.4 Үндсэн хөрөнгө .....   | 14 |
| 3.5.5 Өр төлбөр .....  | 15 |
| 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо .....  | 15 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                           | 16 |
| 3.5.1 Төсвийн төлөвлөлт .....  | 17 |
| 3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....  | 17 |
| 3.5.3 Нэмэлт төсөв .....   | 18 |
| <b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....   | 20 |
| 4.1 Ерөнхий зүйл .....   | 20 |
| 4.2 Материаллаг байдал .....   | 21 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....                            | 21 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....     | 22 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....                               | 22 |
| 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....                                    | 22 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                   | 23 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар .....   | 23 |
| 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....        | 23 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                                  | 24 |
| <b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....  | 24 |
| 5.1 Төлбөрийн акт .....  | 25 |
| 5.2 Албан шаардлага .....  | 26 |
| <b>6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ</b> .....                       | 30 |

## Товчилсон үгийн жагсаалт

|                   |   |
|-------------------|---|
| <b>АДБОУС</b>     | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                         |
| <b>ААНБ</b>       | Аж ахуйн нэгж байгууллага   |
| <b>БОАЖГ</b>      | Байгаль орчин аялал жуулчлалын газар                                  |
| <b>ГХУСАХЗ</b>    | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал                |
| <b>ЕБС</b>        | Ерөнхий боловсролын сургууль  |
| <b>ЖМС</b>        | Жижиг мөнгөн сан  |
| <b>ЗГ</b>         | Засгийн газар   |
| <b>ЗДНХ</b>       | Засаг даргын нөөц хөрөнгө   |
| <b>ЗДТГ</b>       | Засаг даргын тамгын газар   |
| <b>ИТХ</b>        | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал  |
| <b>МНУХ</b>       | Монголын нутгийн удирдлагын холбоо                                    |
| <b>МУЕА</b>       | Монгол улсын ерөнхий аудитор  |
| <b>НДШ</b>        | Нийгмийн даатгалын шимтгэл  |
| <b>ОНЕО</b>       | Орон нутгийн ерөнхий орлого   |
| <b>ОНХО</b>       | Орон нутгийн хөрөнгө оруулалт   |
| <b>ОНХС</b>       | Орон нутгийн хөгжлийн сан   |
| <b>ӨХБЗ</b>       | Өмч хамгаалах байнгын зөвлөл  |
| <b>ТББ</b>        | Төрийн бус байгууллага  |
| <b>ТБОНӨБАУХА</b> | Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах |
| <b>ТЕЗ</b>        | Төсвийн ерөнхийлөн захирагч   |
| <b>ТӨБЗГ</b>      | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                             |
| <b>ТТЗ</b>        | Төсвийн төвлөрүүлэн захирагч  |
| <b>УСНББОУС</b>   | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт           |
| <b>ХАА</b>        | Хөдөө аж ахуй   |
| <b>ХНХС</b>       | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд                                     |
| <b>ХХААХҮС</b>    | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                            |
| <b>ХХК</b>        | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                  |
| <b>ХХОАТ</b>      | Хувь хүний орлогын албан татвар                                       |
| <b>ХХС</b>        | Хоршоо хөгжүүлэх сан  |
| <b>ЭМДС</b>       | Эрүүл мэндийн даатгалын сан   |
| <b>ЭМТ</b>        | Эрүүл мэндийн төв   |



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА,  
Н.ОТГОНЦОГТ ТАНАА

2023.03.25 № ЦА-2023/01-НАСТ-ТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалтай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, цалин, урамшууллыг илүү тооцож олгосон, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрлээ. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралтын 2,6, 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

018020373

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Алтанбулаг сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтээс татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг 27.8 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд төсвийн гүйцэтгэл 90.7 хувьтай буюу 9.3 хувиар хэмнэгдсэн нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 26.7 хувь нь хэрэгжээгүйгээс голлон шалтгаалсан байна.

## **Аудитын гол асуудал**

Алтанбулаг сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 35.5 хувь буюу 473,064.5 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалтай холбоотой зардалд 332,050.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 30,662.4 мянган төгрөг, тавилга эд хогшил, урсгал засварын зардалд 75,554.2 мянган төгрөг, томилолтын зардал 5,572.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 57,050.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 40,569.8 мянган төгрөг, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардалд 14,748.7 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 304,770.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Код:      | Тайлангийн үзүүлэлт                                | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|-----------|--|-----------------------|------------------------|
| <b>1</b>  | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | <b>852,158.70</b>     | <b>655,273.70</b>      |
| <b>31</b> | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                              | <b>227,088.60</b>     | <b>381,169.20</b>      |
| <b>33</b> | <b>АВЛАГА</b>                                      | <b>281,321.60</b>     | <b>206,980.60</b>      |
| <b>35</b> | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                              | <b>343,748.60</b>     | <b>67,124.00</b>       |
| <b>2</b>  | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                 | <b>6,430,987.30</b>   | <b>1,763,748.00</b>    |
| <b>39</b> | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                              | <b>6,430,987.30</b>   | <b>1,763,748.00</b>    |
| 39200     | Биет хөрөнгө                                       | 5,940,334.40          | 1,662,527.20           |
| 39300     | Биет бус хөрөнгө                                   | 490,652.80            | 101,220.80             |
| <b>3</b>  | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 | <b>7,283,146.00</b>   | <b>2,419,021.70</b>    |
| <b>4</b>  | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              | <b>143,744.40</b>     | <b>2,200.60</b>        |
| <b>41</b> | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                   | <b>143,744.40</b>     | <b>2,200.60</b>        |
| 41300     | Өглөг  | 143,744.40            | 2,200.60               |
| <b>5</b>  | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | <b>7,139,401.60</b>   | <b>2,416,821.10</b>    |
| <b>51</b> | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                 | <b>7,139,401.60</b>   | <b>2,416,821.10</b>    |
| 51100     | Засгийн газрын оруулсан капитал                    | 3,388,566.70          | 1,269,358.10           |
| 511002    | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө              | 0                     | 1,269,358.10           |
| 51200     | Хуримтлагдсан үр дүн                               | 770,857.70            | 256,714.80             |
| 51300     | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                   | 2,979,977.20          | 890,748.20             |
| <b>6</b>  | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>7,283,146.00</b>   | <b>2,419,021.70</b>    |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код:       | Тайлангийн үзүүлэлт                            | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|------------|--|-----------------------|------------------------|
| <b>I</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>         | <b>4,343,900.00</b>   | <b>1,872,305.50</b>    |
| <b>11</b>  | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                         | <b>244,804.80</b>     | <b>641,287.70</b>      |
| 110        | Орлогын албан татвар                           | 98,349.60             | 393,836.80             |
| 1100       | Хувь хүний орлогын албан татвар                | 98,349.60             | 393,836.80             |
| 113        | Хөрөнгийн албан татвар                         | 32,176.90             | 51,621.10              |
| 118        | Бусад татвар, төлбөр, хураамж                  | 114,278.40            | 195,829.90             |
| <b>12</b>  | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                     | <b>497,800.60</b>     | <b>203,260.00</b>      |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                    | 487,800.60            | 179,060.00             |
| 122        | Тусламжийн орлого                              | 10,000.00             | 24,200.00              |
| <b>13</b>  | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>           | <b>3,601,294.60</b>   | <b>1,027,757.90</b>    |
| <b>II</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>             | <b>4,182,649.70</b>   | <b>1,897,914.30</b>    |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                           | <b>4,182,649.70</b>   | <b>1,529,831.60</b>    |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>         | <b>3,987,512.90</b>   | <b>1,496,596.20</b>    |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 2,431,925.90          | 426,486.60             |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 313,773.80            | 53,808.80              |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал      | 300,748.40            | 332,562.10             |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал               | 97,190.60             | 28,069.20              |
| 2105       | Нормативт зардал                               | 241,063.00            | 875.40                 |

|            |  |                   |                       |
|------------|--|-------------------|-----------------------|
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 54,278.10         | 63,774.30             |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 1,271.60          | 5,572.80              |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,501.90         | 125,087.40            |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 511,759.60        | 460,359.60            |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>195,136.80</b> | <b>33,235.40</b>      |
| <b>22</b>  | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>-</b>          | <b>368,082.70</b>     |
| <b>III</b> | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>             | <b>161,250.30</b> | <b>(25,608.80)</b>    |
| <b>V</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                   | <b>139,840.30</b> | <b>4,702,184.20</b>   |
| <b>VI</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>   | <b>21,410.00</b>  | <b>(4,727,792.90)</b> |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код:      | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|-----------|---|--|------------------------|
| <b>1</b>  | <b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>    | <b>6,693,413.20</b>                    | <b>6,693,413.20</b>    |
| 2         | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 6,693,413.20                           | 6,693,413.20           |
| 3         | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 424,578.40                             | 424,578.40             |
| 4         | Тайлант үеийн үр дүн                            | 21,410.00                              | 21,410.00              |
| <b>5</b>  | <b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>    | <b>7,139,401.60</b>                    | <b>7,139,401.60</b>    |
| <b>6</b>  | <b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>      | <b>7,139,401.60</b>                    | <b>7,139,401.60</b>    |
| 7         | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | (2,557,701.80)                         | (2,557,701.80)         |
| <b>8</b>  | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>               | <b>4,581,699.80</b>                    | <b>4,581,699.80</b>    |
| 9         | Тайлант үеийн үр дүн                            | (4,727,792.90)                         | (4,727,792.90)         |
| <b>10</b> | <b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>    | <b>2,416,821.10</b>                    | <b>2,416,821.10</b>    |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Код:      | Тайлангийн үзүүлэлт                       | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|-----------|---|------------------------|------------------------|
| <b>I</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b> | <b>4,987,695.60</b>    | <b>1,860,457.10</b>    |
| <b>11</b> | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                    | <b>244,804.80</b>      | <b>641,287.70</b>      |
| 110       | Орлогын албан татвар                      | 98,349.60              | 393,836.80             |
| 1100      | Хувь хүний орлогын албан татвар           | 98,349.60              | 393,836.80             |
| 113       | Хөрөнгийн албан татвар                    | 32,176.90              | 51,621.10              |
| 118       | Бусад татвар, төлбөр, хураамж             | 114,278.40             | 195,829.90             |
| 1180      | Бусад нийтлэг төлбөр, хураамж             | 22,973.90              | 35,268.30              |
| 1181      | Газрын төлбөр                             | -                      | 46,002.80              |
| 1182      | Байгалийн нөөц ашигласны төлбөр           | 91,304.50              | 114,558.80             |
| <b>12</b> | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                | <b>292,466.00</b>      | <b>195,944.60</b>      |
| 120       | Нийтлэг татварын бус орлого               | 272,466.00             | 171,744.60             |
| 122       | Тусламжийн орлого                         | 20,000.00              | 24,200.00              |
| <b>13</b> | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>      | <b>4,450,424.80</b>    | <b>1,023,224.80</b>    |
| <b>II</b> | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>4,635,001.30</b>    | <b>1,116,765.80</b>    |

|             |   |                     |                     |
|-------------|---|---------------------|---------------------|
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>4,635,001.30</b> | <b>1,116,765.80</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                        | <b>3,612,316.40</b> | <b>1,083,075.60</b> |
| 2101        | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                             | 2,434,459.70        | 419,128.60          |
| 2102        | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                | 315,736.70          | 53,935.90           |
| 2103        | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                     | 296,848.60          | 332,050.60          |
| 2104        | Хангамж, бараа материалын зардал                              | 73,421.10           | 32,651.20           |
| 2105        | Нормативт зардал  | 259,334.10          | 159.00              |
| 2106        | Эд хогшил, урсгал засварын зардал                             | 45,013.20           | 86,541.80           |
| 2107        | Томилот, зочны зардал   | 1,271.60            | 5,572.80            |
| 2108        | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж      | 38,506.00           | 58,143.20           |
| 2109        | Бараа үйлчилгээний бусад зардал                               | 147,725.50          | 94,892.50           |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                       | <b>1,022,684.90</b> | <b>33,690.30</b>    |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>    | <b>352,694.40</b>   | <b>743,691.30</b>   |
| <b>V</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>              | <b>185,581.00</b>   | <b>589,610.60</b>   |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                       | <b>185,581.00</b>   | <b>589,610.60</b>   |
| 2200        | Дотоод эх үүсвэрээр   | 185,581.00          | 589,610.60          |
| <b>VI</b>   | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>  | <b>(185,581.00)</b> | <b>(589,610.60)</b> |
| <b>VII</b>  | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b> | <b>(160,000.00)</b> | <b>-</b>            |
| <b>23</b>   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>             | <b>160,000.00</b>   | <b>-</b>            |
| <b>VIII</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>      | <b>7,113.40</b>     | <b>154,080.60</b>   |
| 101         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл              | 219,975.10          | 227,088.60          |
| 20          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл             | 227,088.60          | 381,169.20          |

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код        | Үзүүлэлт                                       | Төлөвлөгөө          | Гүйцэтгэл           | Хэтрэлт/хэмнэлт   | Хувь         |
|------------|--|---------------------|---------------------|-------------------|--------------|
| <b>II</b>  | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>       | <b>1,467,658.40</b> | <b>1,331,616.84</b> | <b>136,041.56</b> | <b>90.73</b> |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                           | <b>1,050,380.60</b> | <b>1,026,846.29</b> | <b>23,534.31</b>  | <b>97.76</b> |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>         | <b>1,035,607.60</b> | <b>1,012,097.63</b> | <b>23,509.97</b>  | <b>97.73</b> |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 421,946.80          | 419,128.57          | 2,818.23          | 99.33        |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,540.30           | 53,935.90           | 604.40            | 98.89        |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал      | 343,240.70          | 332,050.63          | 11,190.07         | 96.74        |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал               | 33,236.30           | 30,662.45           | 2,573.85          | 92.26        |
| 2105       | Нормативт зардал                               | 159.00              | 159.00              | -                 | 100.00       |

|            |  |                     |                     |                     |               |
|------------|--|---------------------|---------------------|---------------------|---------------|
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 75,748.20           | 75,554.20           | 194.00              | 99.74         |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 5,985.60            | 5,572.80            | 412.80              | 93.10         |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 57,050.00           | 54,464.26           | 2,585.74            | 95.47         |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 43,700.70           | 40,569.82           | 3,130.88            | 92.84         |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>14,773.00</b>    | <b>14,748.66</b>    | <b>24.34</b>        | <b>99.84</b>  |
| 2132       | Бусад урсгал шилжүүлэг                                   | 14,773.00           | 14,748.66           | 24.34               | 99.84         |
| <b>22</b>  | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>417,277.80</b>   | <b>304,770.55</b>   | <b>112,507.25</b>   | <b>73.04</b>  |
| <b>III</b> | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>1,467,658.40</b> | <b>1,444,423.24</b> | <b>23,235.16</b>    | <b>98.42</b>  |
| <b>32</b>  | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | <b>1,244,241.40</b> | <b>1,346,808.29</b> | <b>(102,566.89)</b> | <b>108.24</b> |
| <b>35</b>  | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | <b>203,417.00</b>   | <b>73,414.95</b>    | <b>130,002.05</b>   | <b>36.09</b>  |
| <b>36</b>  | <b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>                 | <b>20,000.00</b>    | <b>24,200.00</b>    | <b>(4,200.00)</b>   | <b>121.00</b> |
| 4          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | -                   | 90,832.43           | <b>(90,832.43)</b>  | -             |
| 5          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | -                   | 203,638.82          | <b>(203,638.82)</b> | -             |
| <b>6</b>   | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                  | <b>0.14</b>         | <b>0.14</b>         | <b>0.00</b>         | <b>100.00</b> |
| <b>61</b>  | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                  | <b>0.01</b>         | <b>0.01</b>         | <b>0.00</b>         | <b>100.00</b> |
| <b>62</b>  | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                  | <b>0.07</b>         | <b>0.07</b>         | <b>0.00</b>         | <b>100.00</b> |
| <b>65</b>  | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                               | <b>0.07</b>         | <b>0.07</b>         | <b>0.00</b>         | <b>100.00</b> |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код        | Үзүүлэлт   | ТЗ цэвэр дүн      |
|------------|--|-------------------|
| <b>II</b>  | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>386,978.16</b> |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>110,975.87</b> |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>79,815.76</b>  |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 1,988.80          |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 10,987.60         |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,516.70         |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 54,322.66         |
| 213        | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 31,160.11         |
| 2132       | Бусад урсгал шилжүүлэг                                   | 18,941.60         |
| 2133       | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                            | 12,218.51         |
| <b>22</b>  | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>276,002.30</b> |
| 2200       | Дотоод эх үүсвэрээр                                      | 276,002.30        |
| <b>I</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>386,978.16</b> |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 386,978.16        |
| <b>III</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>          | <b>0.00</b>       |
| 9          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 0.00              |
| 10         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 0.00              |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Алтанбулаг сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх.”* гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.
- ХХААХҮС-ын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” хэрэгжиж ирсэн.
- ЗГ-ын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга, хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам” хэрэгжиж эхэлсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Алтанбулаг сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг*”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “*Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам*”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,864,124.3 мянган төгрөгөөр буюу 33.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт             |
|--|--------------------|--------------------|----------------------|
| Б  | 1                  | 2                  | 3=2-1                |
| Мөнгөн хөрөнгө                               | 227,088.6          | 381,169.2          | 154,080.6            |
| Авлага                                       | 281,321.6          | 206,980.6          | (74,341.0)           |
| Бараа материал                               | 343,748.6          | 67,124.0           | (276,624.6)          |
| Үндсэн хөрөнгө                               | 6,430,987.2        | 1,763,747.9        | (4,667,239.3)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>7,283,146.0</b> | <b>2,419,021.7</b> | <b>(4,864,124.3)</b> |
| Өр төлбөр                                    | 143,744.4          | 2,200.6            | (141,543.8)          |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 7,139,401.6        | 2,416,821.1        | (4,722,580.5)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>7,283,146.0</b> | <b>2,419,021.7</b> | <b>(4,864,124.3)</b> |

сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бөгөөд өөрчлөлтийг данс тус бүрээр тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 227,088.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 381,169.2 мянган төгрөг болж, 154,080.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                   | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------|------------------|------------------|------------------------|
| Банканд байгаа бэлэн мөнгө | 227,088.5        | 381,169.2        | 154,080.7              |
| <b>Дүн</b>                 | <b>227,088.6</b> | <b>381,169.2</b> | <b>154,080.6</b>       |

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНЕО-ын дансанд 177,530.4 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 111,707.3 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 91,931.5 мянган төгрөг зэрэг нийт 381,169.2 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 281,321.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 206,980.6 мянган төгрөг болж, 74,341.0 мянган төгрөгөөр буюу 26.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------|----------------|-----------------|------------------------|
|----------|----------------|-----------------|------------------------|

|                                 |                  |                  |                   |
|---------------------------------|------------------|------------------|-------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 79.7             | -                | (79.7)            |
| Зээлийн хүүгийн авлага          | 8,172.4          | 5,482.9          | (2,689.5)         |
| Байгууллагаас авах авлага       | 7,799.6          | -                | (7,799.6)         |
| Зээлийн авлага                  | 265,269.9        | 201,497.7        | (63,772.2)        |
| <b>Дүн</b>                      | <b>281,321.6</b> | <b>206,980.6</b> | <b>(74,341.0)</b> |

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэл 74,341.0 мянган төгрөгөөр буурахад ЭМТ-ийн ЭМДС-аас авах санхүүжилтийн 7,799.6 мянган төгрөгийн авлага, ХХС-ийн зээлийн хүүгийн авлага 2,689.6 мянган төгрөг, зээлийн авлага 63,772.2 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

ХХС-ийн дансанд 2013-2021 онуудад олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн авлагын нийт 19 зээлдэгчийн 206,980.6 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- *ХХС-ийн авлагын тооцоог тулган баталгаажуулаагүйгээс Санхүүгийн байдлын тайлангийн зээлийн авлага, хүүгийн авлагын дүн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн дүнгээс 5,453.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.*

#### **3.4.3 Бараа материал**

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 343,748.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 67,124.0 мянган төгрөг болж, 276,624.6 мянган төгрөгөөр буурсан байна.

#### **Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл**

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт                     | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|------------------|-----------------|------------------------|
| Тусгай зориулалттай материал | 478.0            | 1,177.8         | 699.8                  |
| Эм боох материал             | 26,478.1         | -               | (26,478.1)             |
| Бичиг хэргийн материал       | 15,596.3         | 16,862.1        | 1,265.8                |
| Аж ахуйн материал            | 239,280.4        | 45,012.8        | (194,267.6)            |
| Шатах тослох материал        | 2,552.6          | 2,112.1         | (440.5)                |
| Барилгын засварын материал   | 261.0            | 859.5           | 598.5                  |
| Хүнсний материал             | 6,751.8          | 243.8           | (6,508.0)              |
| Бусад хангамжийн материал    | 52,350.4         | 855.9           | (51,494.5)             |
| <b>Дүн</b>                   | <b>343,748.6</b> | <b>67,124.0</b> | <b>(276,624.6)</b>     |

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Материалын дансны үлдэгдэл 276,624.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 38,079.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 38,671.0 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж, улсын төсвийн байгууллагууд болох / Данбо цэцэрлэгийн 34,852.0 мянган төгрөг, 3 дугаар цэцэрлэгийн 16,588.8 мянган төгрөг, Алтанбулаг 1 дүгээр цэцэрлэгийн 25,583.3 мянган

төгрөг, Соёлын төвийн 7,763.8 мянган төгрөг сумын ЭМТ 40,856.8 мянган төгрөг, ЕБС-ийн 150,388.4 мянган төгрөг / газруудын бараа материалын үлдэгдлийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох яамдад шилжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

### **Аудитын илрүүлэлт:**

Алтанбулаг сумын ТТЗ-ийн харьяаны дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, болон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэсэн байна. Үүнд:

- ИТХ-ын худалдан авалтын 4,673.6 мянган төгрөгийн цахим баримт нь бөөн дүнгээр бүртгэгдсэн,
- ИТХ нь ГХУСАХЗ-аас цагдаагийн тасгийн автомашины урсгал засварт 1,440.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч зарцуулахдаа ӨХБЗ-ийн хурлын тэмдэглэл, техникийн комиссын актыг үндэслээгүй,
- ЗДТГ нь нярвын шатахууны тайланд 7,723.5 мянган төгрөгийн орлого дутуу бүртгэж, жолоочийн тооцооны хуудсыг заавар аргачлалын дагуу бүрэн хөтөлж баталгаажуулаагүй,
- ЗДТГ-ын худалдан авалтын 21,480.1 мянган төгрөгийн цахим баримт нь бөөн дүнгээр бүртгэгдсэн,
- Биеийн тамир спортын газарт шилжүүлсэн гэх 3,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий байгаль орчны үнэлгээ, 2,200.0 мянган төгрөгийн өртөг бүхий спорт заалны геологийн судалгааг хүлээлгэн өгсөн акт, хүлээн авсан орлогын баримт зэрэг анхан шатны баримтуугээр зардлаар тайлагнасан байна.

### **3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,085,635.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,156,165.1 мянган төгрөг болж, 4,929,470.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                         | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|--------------------|--------------------|------------------------|
| Барилга, байгууламж, орон сууц   | 4,100,367.9        | 458,670.6          | (3,641,697.3)          |
| Авто-тээврийн хэрэгсэл           | 302,486.2          | 232,690.6          | (69,795.7)             |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 732,014.0          | 275,640.0          | (456,374.0)            |
| Тавилга, аж ахуйн эд хогшил      | 227,786.5          | 74,686.1           | (153,100.4)            |
| Зам гүүр, барилга байгууламж     | 2,067,807.7        | 2,011,599.5        | (56,208.2)             |
| Номын фонд                       | 20,389.8           | -                  | (20,389.8)             |
| Бусад үндсэн хөрөнгө             | 138,847.0          | -                  | (138,847.0)            |
| Программ хангамж                 | 15,197.9           | 1,999.4            | (13,198.5)             |
| Бусад биет бус хөрөнгө           | 480,738.2          | 100,879.0          | (379,859.2)            |
| <b>Дүн</b>                       | <b>8,085,635.2</b> | <b>3,156,165.1</b> | <b>(4,929,470.1)</b>   |

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,929,470.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 49,432.2 мянган төгрөгийн /ухаалаг дэлгэц, цахим индэр, суурин болон зөөврийн компьютер, принтер, хяналтын камер/ машин, тоног төхөөрөмж, ОНХС болон бусад эх үүсвэрээс 15,000.0 мянган төгрөгийн барилга, 4,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 54,777.0 мянган төгрөгийн зам гүүрийн барилга зэрэг нийт 73,777.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан зэргээр нэмэгдэж, улсын төсвийн байгууллагууд болох / Данбо цэцэрлэгийн 351,277.0 мянган төгрөг, 3 дугаар цэцэрлэгийн 741,737.1 мянган төгрөг, Алтанбулаг 1 дүгээр цэцэрлэгийн 893,454.2 мянган төгрөг, Соёлын төвийн 276,114.5 мянган төгрөг сумын ЭМТ 530,936.4 мянган төгрөг, ЕБС-ийн 2,259,160.0 мянган төгрөг / газруудад бүтцийн өөрчлөлтөөр нийт 5,052,679.2 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 143,744.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,200.6 мянган төгрөг болж 141,543.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                           | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------------|------------------|-----------------|------------------------|
| Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг | 130,000.0        | -               | (130,000.0)            |
| Байгууллагад төлөх өглөг           | 13,744.4         | 2,200.6         | (11,543.8)             |
| <b>Дүн</b>                         | <b>143,744.4</b> | <b>2,200.6</b>  | <b>(141,543.8)</b>     |

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 2021 онд үүссэн Алтанбулаг сумын халаалтын зуухны тоног төхөөрөмж худалдаж авах 130,000.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулсан, сумын ЭМТ-ийн 9,161.6 мянган төгрөг, ЕБС-ийн 450.0 мянган төгрөг, Соёлын төвийн 3,400.5 мянган төгрөгийн өр төлбөр бүтцийн өөрчлөлтөөр холбогдох яамдуудад шилжүүлсэн зэргээс шалтгаалан буурсан байна.

Байгууллагад төлөх өглөгийн дансанд ЗДТГ-ын тайлант онд НДШ-ийн дутуу төлөлтэй холбоотой 1,468.3 мянган төгрөг, ОНХО-ын дансанд бүртгэлтэй 2000 онд мал бүхий иргэдэд өвс бэлдүүлсний ажлын хөлсний төлөгдөөгүй 732.3 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Илрүүлэлт:

- ЗДТГ нь төсвийг зохистой удирдаагүйгээс НДШ-ийн тайлангаар 1,468.3 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан атал санхүүгийн тайланд тусгаагүй,
- Он дамжсан насжилт өндөртэй 732.3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,139,401.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,416,821.1 мянган төгрөг болж, 4,722,580.5 мянган төгрөгөөр буурсан байна.

## Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|--------------------|--------------------|------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,388,566.7        | 1,269,358.0        | (2,119,208.7)          |
| Хуримтлагдсан үр дүн  | 770,857.7          | 256,714.8          | (514,142.9)            |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 2,979,977.2        | 890,748.2          | (2,089,229.0)          |
| <b>Дүн</b>  | <b>7,139,401.6</b> | <b>2,416,821.1</b> | <b>(4,722,580.5)</b>   |

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь, ЕБС, соёлын төв, цэцэрлэгүүд, сумын ЭМТ зэрэг байгууллагуудыг холбогдох яамдад шилжүүлснээс шалтгаалсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:**

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар “ 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай” тогтоолоор 502,803.0 мянган төгрөгийн татварын орлого, 110,500.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 613,303.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсныг 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор татварын орлогыг 335,772.3 мянган төгрөг, татварын бус орлогыг 80,000.0 мянган төгрөг болгон бууруулсан бөгөөд гүйцэтгэлээр 739,617.2 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 27.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

## Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| д/д | Үзүүлэлт   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү      | Хувь  |
|-----|--|------------|-----------|------------|-------|
| 1   | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 175,536.3  | 217,351.5 | (41,815.2) | 123.8 |
| 2   | Үйл ажиллагааны орлого   | 123,236.0  | 119,402.8 | 3,833.2    | 96.9  |
| 3   | Хөрөнгийн орлого   | 21,000.0   | 41,875.8  | (20,875.8) | 199.4 |
| 4   | Хөрөнгө борлуулсны орлого  | 16,000.0   | 15,206.5  | 793.5      | 95.0  |
| 5   | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар  | 8,000.0    | 4,140.4   | 3,859.6    | 51.8  |
| 6   | Бууны албан татвар   | 1,400.0    | 1,290.0   | 110.0      | 92.1  |
| 7   | Малд ногдуулах албан татвар  | 25,000.0   | 46,190.7  | (21,190.7) | 184.8 |
| 8   | Улсын тэмдэгтийн хураамж   | 6,000.0    | 6,260.3   | (260.3)    | 104.3 |
| 9   | Хог хаягдлын үйлчилгээний хураамж  | 26,500.0   | 17,660.0  | 8,840.0    | 66.6  |
| 10  | Ургамал ашигласны төлбөр   | -          | 108.0     | (108.0)    | -     |
| 11  | Дуудлага худалдаа  | 23,743.0   | 46,002.8  | (22,259.8) | 193.8 |
| 12  | Ан амьтны нөөц ашигласны төлбөр  | 2,468.0    | 640.0     | 1,828.0    | 25.9  |
| 13  | Ойн нөөц ашигласны төлбөр  | 63,578.4   | 113,810.7 | (50,232.3) | 179.0 |

|    |   |                  |                  |                    |              |
|----|---|------------------|------------------|--------------------|--------------|
|    | Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр | 6,000.0          | 11,348.0         | (5,348.0)          | 189.1        |
| 14 | Торгуулийн орлого                         | 60,000.0         | 74,204.5         | (14,204.5)         | 123.7        |
| 15 | Бусад орлого                              | 20,000.0         | 24,125.2         | (4,125.2)          | 120.6        |
|    | <b>Дүн</b>                                | <b>578,461.7</b> | <b>739,617.2</b> | <b>(161,155.5)</b> | <b>127.8</b> |

Орлогын төлөвлөгөө 161,155.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого 123.8 хувиар, хөрөнгийн орлого 199.4 хувиар, малын тоо толгойн албан татварын орлого 184.8 хувиар, дуудлага худалдааны орлого 193.7 хувиар, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлого 189.1 хувиар, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 179.0 хувиар, нэр заагдаагүй бусад орлого 120.6 хувиар, торгуулийн орлого 123.7 хувиар тус тус биелсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

#### **Давсан орлого**

- *ЗГ-ын 2022 оны 107, 192, 194 дүгээр тогтоолуудаар төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдсэн,*
- *Газрын дуудлага худалдааны орлого 93.8 хувиар давж биелсэн нь газрын дуудлага худалдааг сайн зохион байгуулсан болон иргэд аж ахуйн нэгжийн оролцооноос шалтгаалсан,*
- *Хөрөнгийн орлого давж биелсэн нь банкны хүүгийн орлогоос шалтгаалсан байна.*

#### **Тасарсан орлого:**

- *Хөрөнгө борлуулсны орлого 95.0 хувийн биелэлтэй байгаа нь иргэд, аж нэгжээс борлуулах хөрөнгийн борлуулалт буурсан,*
- *Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 51.8 хувьтай байгаа нь эдийн засгийн хямралтай холбоотойгоор аж ахуйн нэгж байгууллагуудын орлого буурсан,*
- *Алтанбулаг боомтын зорчигчийн хөдөлгөөн 05 сар хүртэл хаагдсантай холбоотойгоор хог хаягдлын хураамжийн орлого тасарсан байна.*

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,590,500.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,590,500.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дүгээр тогтоолоор нийт орлого, зарлагыг тус бүр 1,595,722.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсөвт хийгдсэн тодотгол болон зохицуулалтаар 128,064.4 мянган төгрөгөөр бууруулан дараах өөрчлөлтүүд орж **1,467,658.4** мянган төгрөгөөр эцэслэн батлагдсан байна. Үүнд:

**Сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор:**

**Төсвийн орлогын өөрчлөлт:**

- Цалин хөлс,шагнал урамшуулал түүнтэй адилтгах орлогыг 21,463.7 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн орлогыг 10,000.0 мянган төгрөгөөр,
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 41,378.2 мянган төгрөгөөр,
- Торгуулийн орлогыг 30,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан.
- Үйл ажиллагааны орлогыг 38,500.0 мянган төгрөгөөр,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 5,000.0 мянган төгрөгөөр,
- Малын тоо толгойн албан татварын орлогыг 25,000.0 мянган төгрөгөөр,
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Урьд оны үлдэгдлээс 111,917.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр өөрчлөлт оруулсан байна.

**Төсвийн зарлагын өөрчлөлт:**

- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор ЗДТГ-ын цалин хөлс болон урсгал зардлыг 27,388.5 мянган төгрөгөөр,
- ИТХ-ын урсгал зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр,
- ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг он дамжсан хөрөнгийн зардлыг дутуу тусгасан 59,756.0 мянган төгрөгөөр,
- ХХС-ийн үйл ажиллагааны урсгал зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр,
- Соёлын төвийн халаалтын зардлыг гүйцэтгэлд үндэслэн 6,644.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн,
- Орон нутгаас санхүүжих улсын төсвийн байгууллага /ЭМТ 14,141.1 мянган төгрөг, 1-р Цэцэрлэг 45,362.9 мянган төгрөг, 2-р цэцэрлэг 39,237.8 мянган төгрөг, 3-р цэцэрлэг 25,601.9 мянган төгрөг, ЕБС 107,509.6 мянган төгрөг, /-ын тогтмол зардлыг 231,853.7 мянган төгрөгөөр бууруулсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 25 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 604,897.4 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 242,521.8 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төслийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар тогтоолоор татварын орлогыг 502,803.6 мянган төгрөг, татварын бус орлогыг 110,000.0 мянган төгрөг,

төсөвт байгууллагын өөрийн орлогыг 500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 135,000.0 мянган төгрөг, зэрэг нийт 1,595,722.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор тус суманд аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 398,257.9 мянган төгрөг болгон бууруулсантай холбогдуулан сумын төсвийн тодотгол болон зохицуулалтаар татварын орлогыг 498,461.7 мянган төгрөг, татварын бус орлогыг 80,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 246,917.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 242,521.8 мянган төгрөг зэрэг нийт сумын төсвийг **1,467,658.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,467,658.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,387,658.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 60,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 5,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгаас авах санхүүгийн дэмжлэг 398,257.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 242,521.8 мянган төгрөг, татварын болон татварын бус орлогоос 739,617.2 мянган төгрөг, ОНХС-д иргэн, ААНБ-аас өгсөн хандивын орлого 24,200.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,500.0 мянган төгрөг, ХХС-ийн эргэн төлөлтөөс 71,914.9 мянган төгрөг зэрэг нийт **1,478,011.8** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,331,616.8 мянган төгрөг буюу 90.7 хувьтай тайлагнагдсан нь орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 2,818.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 604.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11,190.1 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардал 2,573.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 194.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 412.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2,585.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3,130.9 мянган төгрөг, тэтгэмж, урамшуулал 24.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХО-аар хэрэгжүүлэх 2 төсөл арга хэмжээнд 60,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэл 100 хувьтай тайлагнагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 14 төсөл, арга хэмжээнд 357,277.8 төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 244,770.5 мянган

төгрөгийн санхүүжилт олгож “Жишиг сум” төсөл хэрэгжихтэй холбоотойгоор 4 төсөл арга хэмжээг зогсоож, үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 2,451.4 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний зардалд дээд шатны төсвийн захирагчдаас 355,994.6 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28,032.1 мянган төгрөг, сумын үерийн далангийн засварт зориулан ААНБ-аас өгсөн 500.0 мянган төгрөгийн хандивын орлого зэрэг нийт 386,978.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс хангамжийн материалын зардалд 1,988.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварт 10,987.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 12,516.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 54,322.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 18,941.6 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 276,002.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 12,218.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч цаашид /*Алтанбулаг сумын ТТЗ гэх*/-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бусад хууль тогтоомжийн зөрчилтэй холбоотой ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон, захиргааны актыг боловсруулахдаа эрх зүйн үндэслэлийг буруу сонгосон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ бүртгэсэн, насжилт өндөртэй он дамнасан өр төлбөр, үндсэн хөрөнгийн ангилал, элэгдэл тооцох хугацааг баримтлаагүй, зэрэг зөрчилд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/77 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,705,488.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,054.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 18,938.4 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, цэцэрлэг, сумын ЭМТ зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яаманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болох 1,897,914.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **18,979.1** мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлийг аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, ЗДНХ-ийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэл хүргүүлсний дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна.. Үүнд:

- *Төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан аймгаас өгөх санхүүгийн дэмжлэгийг 206,639.5 мянган төгрөгөөр бууруулсан тул*

төсвийн тодотгоол, зохицуулалтаар төсвийн зардлыг орлогын эх үүсвэртэй уялдуулан 128,064.4 мянган төгрөгөөр бууруулсан.

- Төсвийн зарлагын чиглэлээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласнаар 136,041.5 мянган төгрөг буюу 9.3 хувийн хэмнэлт гаргасан.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлын 2,195.2 мянган төгрөгийг хэмнэлтэд тооцон ОНХО-ын дансанд татан төвлөрүүлсэн.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 10. ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт*

| Үзүүлэлт                     | Мэдээлбэл зохих | Мэдээлсэн  | Хугацаа хоцроосон | Мэдээлээгүй |
|------------------------------|-----------------|------------|-------------------|-------------|
| Засаг дарга                  | 167             | 165        | 2                 |             |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 161             | 159        | 2                 |             |
| Засаг даргын тамгын газар    | 161             | 159        | 2                 |             |
| <b>Дүн</b>                   | <b>489</b>      | <b>483</b> | <b>6</b>          |             |

*Эх сурвалж: шилэн дансны цахим хуудас*

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулаагүй мэдээлэл нь материаллаг байдлын шинж чанарыг хангахгүй тул Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.1. Илрүүлэлт: ИТХ-ын нарийн бичгийн даргын тушаалаар бус ИТХ-ын 2022 оны 57 дугаар тогтоолоор төлөөлөгчдийн урамшуулалд **4,480.0** мянган төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх “Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга тушаал гаргана”, 55.1 дэх “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Холбогдох хууль, эрхийн актыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

**2.1 Илрүүлэлт:** ОНХС-ийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч “Ачлалт төмөр хэлхээ” ХХК-тай байгуулсан СЭААБСЗДТГ/202209009 дугаартай гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөрийн 30 хувь 9,827.4 мянган төгрөгийн санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр олгосон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь “Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө”, Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 41.1-т заасан “Урьдчилгаа төлбөр олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Ажил үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, тендерийн баримт бичигт заасан шалгуурт нийцүүлэн зохион байгуулж, урьдчилгаа төлбөр олгох тохиолдолд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулж байх зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй **20,864.9** мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                 | Биелэлт   |                 |             |
|-----------------|------------------------|-----------------|-----------|-----------------|-------------|
|                 | Тоо                    | Дүн             | Тоо       | Дүн             | Хувь        |
| Төлбөрийн акт   | 3                      | 1,532.0         | 3         | 1,532.0         | 100.0       |
| Албан шаардлага | 5                      | 22,950.8        | 5         | 22,950.8        | 100.0       |
| Зөвлөмж         | 3                      | 20,864.9        | 2         | -               | 0.0         |
| <b>Нийт дүн</b> | <b>11</b>              | <b>45,347.7</b> | <b>10</b> | <b>24,482.8</b> | <b>54.0</b> |

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтын төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Алтанбилэг ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1663 дугаартай “Үл хөдлөх хөрөнгө бэлэглэлийн гэрээ”-гээр дулаан дамжуулах сүлжээний зориулалтай уурын зуухны барилга, ажилчдын ахуйн байрны зориулалтай барилга, блокон хашаа, 1662 дугаартай газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр 221м.кв талбайг орон нутгийн өмчид шилжүүлэн авч, тус компаниас уурын зуухны 2 тогоо, дагалдах тоног төхөөрөмжүүдийг 130,000.0 мянган төгрөгөөр худалдан авахаар харилцан тохиролцсон байна.

Сумын ЗДТГ-тай 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 1666 дугаартай зээлээр худалдах, худалдан авах гэрээ байгуулан үндсэн хөрөнгөд 130,000.0 мянган төгрөгийн уурын зуух, дагалдах тоног төхөөрөмжийг бүртгэлд авсан боловч тайлант онд Алтанбилэг ХХК-ийн захирал П.Батсайхан нь Иргэний анхан шатны шүүхэд төлбөрөө гэрээнд заасны дагуу барагдуулаагүй гэх үндэслэлээр гэрээг цуцлах нэхэмжлэл гаргасан байна.

“Бэлэглэлийн гэрээ” нь бэлэглэгч этгээдийг ноцтой гомдоовол бэлэглэсэн хөрөнгийг буцаан авна гэдэг хууль, эрх зүйн зохицуулалттай тул иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авах, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг бэлэглэлийн гэрээгээр бус холбогдох бусад хууль, эрх зүйн зохицуулалтыг үндэслэн шилжүүлэн авах, он дамжсан зээлээр худалдан авах гэрээ байгуулахгүй байх нь зүйтэй юм.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **10,519.1** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс 6,921.6 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй 3,3597.5 мянган төгрөгийн алдааг цаашид арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

##### Залруулсан алдаа:

- ЗДТГ нь НДШ-ийн тайлангаар 1,468.3 мянган төгрөгийн өр төлбөр, ХХС-ийн мэдээллийн нэгдсэн сангийн дүнгээс 5,453.3 мянган төгрөгөөр

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

*дутуу илэрхийлсэн зээлийн авлагыг тус тус санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан бүртгэлийн алдааг залруулав.*

#### **Залруулаагүй алдаа:**

- *Хангамжийн бараа материалын зардлын дансыг сонгохдоо цалингийн зардлын 210101 тоот дансанд 3,597.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж, тайлагнасан алдааг залруулагдаагүй алдаагаар тооцсон.*

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.2-д "Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын дансуудад хуримтлуулан бүртгэнэ.", 3.5-д "Төсвийн зардлыг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомж, сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг зарлагдахдаа дансны нэгдсэн төлөвлөгөөний дагуу холбогдох дэд дансанд бүртгэх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **55,879.5** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 971.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 44,048.0 төгрөгийн албан шаардлага, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 10,859.8 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

### **5.1 Төлбөрийн акт**

1. ЗДТГ нь цалингийн тооцооллыг хянаагүйгээс 4 албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг давхардуулан илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь "... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон **553.5** мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ЗДТГ-ын дарга Ү.Янжиндуламд ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 1-3 дугаар улиралд тус бүр 40 хувиар олгосон атал сумын Засаг даргын 2022 оны Б/40 дүгээр захирамжаар 4 дүгээр улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг 80 хувиар олгохоор шийдвэрлэж, олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн мөнгөн урамшуулалд илүү олгосон **418.2** мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн, төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд харилцагч байгууллагуудаас нийт **26,153.7** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- ЗДТГ-ын 21,480.1 мянган төгрөг,
- ИТХ-ын 4,673.6 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

### ИТХ:

2. Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 195.4 мянган төгрөг, хурлын урсгал зардлаас сумын Цагдаагийн тасагт согтуурлын хэмжээг тогтоох тоног төхөөрөмж худалдан авахад 700.0 мянган төгрөг зэрэг нийт **895.4** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх, шаардлагатай тохиолдолд дээд шатны төсвийн захирагчаас зөвшөөрөл авч төсөвт зохицуулалт хийж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Хүний үнэ цэнэ ТББ-д сургалт зохион байгуулах №2022/01-13 тоот гэрээний дагуу **4,300.0** мянган төгрөгөөр сургалт зохион байгуулсан нь Төсвийн

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Анхан шатны баримтын бүрдэлгүй болон мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн зэрэг нийт **12,698.9** мянган төгрөгийн дараах ажил, гүйлгээнүүдийг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 2.7 дахь "Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

#### **ЗДТГ:**

- ЖМС-ийн дансанд төвлөрсөн наадмын арга хэмжээнд зориулан ААНБ-аас өгсөн 4,000.0 мянган төгрөгийн хандивын орлогыг төрийн сангийн дансанд тушаалгүйгээр зарцуулсан бөгөөд холбогдох албан тушаалтны цохолт хийсэн болон хүлээн авсан хүний гарын үсэггүй бэлэн мөнгө хүссэн өргөдөл, бэлэн мөнгөний зарлагын баримт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүй нийт 1,318.9 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг ЖМС-аас гүйцэтгэсэн байна.
- Хүлээлгэн өгсөн акт, хүлээн авсан баримт зэрэг анхан шатны баримтгүйгээр аймгийн Биеийн тамир, спортын газарт 3,000.0 мянган төгрөгийн байгаль орчны үнэлгээ, 2,200.0 мянган төгрөгийн спорт заалны геологийн судалгааг шилжүүлж, бүртгэл тайлангаас хассан байна.

#### **ИТХ:**

- Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийг Улаанбаатар хотод МНУХ-ны сургалтад хамруулахад буудлын зардалд 2,180.0 мянган төгрөгийг Цэлмүүн трейд ХХК-д шилжүүлсэн боловч буудлын үйлчилгээ авсан төлбөрийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Алтанбулаг сумын ТТЗ-ийн харьяа дараах байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан Үүнд:

- *ИТХ нь эвдрэл гэмтлийг нотлох техникийн комиссын акт, ӨХБЗ-ийн хурлын тэмдэглэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ГХУСАХЗ-аас Цагдаагийн тасгийн автомашины урсгал засварт 1,440.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч зарцуулсан,*
- *ЗДТГ нь нярвын шатахууны тайланд 7,723.5 мянган төгрөгийн орлого дутуу бүртгэсэн бөгөөд жолоочийн тооцооны хуудсыг заавар аргачлалын дагуу бүрэн хөтөлж, баталгаажуулаагүй байна.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

#### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: ИТХ-н тайлант жилд үндсэн хөрөнгийн бүртгэлд шинээр орлого авсан 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын жилийг үндэслэлгүй тогтоож, бүртгэсэн байна.

Энэ нь төсвийн хөрөнгийг үнэгүйдүүлэх эрсдэлийг үүсгэж байгаа бөгөөд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.4-т заасан “*Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа*”-г зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацааг үнэн зөв тогтоож, бүртгэх, хөрөнгийн ашиглалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах.

2.3. Илрүүлэлт: ИТХ нь үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэж тавилга эд хогшлын дансанд 5 нэр төрлийн **964.0** мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх ТӨЗГ-ын 2019 оны 217 дүгээр тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд

дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн 5.4 дэх “*Үндсэн хөрөнгийн бүртгэл*” гэсэн заалттай нийцээгүй байна.

2.4. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг орлого авахдаа дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгэж байх зөвлөмж өгөв.

### **3. Санхүүгийн байдлын тайлангийн данстай холбоотой асуудал**

3.1.Илрүүлэлт: ОНЕО-ын дансанд 2000 онд мал бүхий иргэдэд өвс бэлдүүлсний ажлын хөлстэй холбоотой гэх насжилт өндөр 732.3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.6-дахь “*...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2.Зөвлөмж нь: Насжилт өндөртэй өр төлбөрийн эзэн холбогдогчийг тогтоож, барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж өгөв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага,зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр   | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                | Буруу тусган илэрхийлсэн |                | Үүнээс     |                |              |                | Зөвлөмж  |                |
|--|------------|-----------------|-----------------------------------|----------------|--------------------------|----------------|------------|----------------|--------------|----------------|----------|----------------|
|  | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн            | Тоо                      | Дүн            | Залруулсан |                | Залруулаагүй |                | Тоо      | Дүн            |
|  |            |                 |                                   |                |                          |                | Тоо        | Дүн            | Тоо          | Дүн            |          |                |
| ЗДТГ-тай холбоотой 1,468.3 мянган төгрөгийн өр төлбөр, 5,453.3 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу бүртгэсэн алдааг залруулав. | 1          | 6,921.6         | 1                                 | 6,921.6        |                          |                | 1          | 6,921.6        |              |                |          |                |
| Хангамжийн бараа материалын зардлын дансыг сонгохдоо цалингийн зардлын дансанд бүртгэсэн.  | 1          | 3,597.5         |                                   |                | 1                        | 3,597.5        |            |                | 1            | 3,597.5        | 1        | 3,597.5        |
| <b>Дүн</b>   | <b>2</b>   | <b>10,519.1</b> | <b>1</b>                          | <b>6,921.6</b> | <b>1</b>                 | <b>3,597.5</b> | <b>1</b>   | <b>6,921.6</b> | <b>1</b>     | <b>3,597.5</b> | <b>1</b> | <b>3,597.5</b> |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр   | Нийт зөрчил |          | Үүнээс        |       |                 |          |         |     |                                      |                     |   |     |
|--|-------------|----------|---------------|-------|-----------------|----------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|  |             |          | Төлбөрийн акт |       | Албан шаардлага |          | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн   | Тоо             | Дүн      | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Ур чадварын нэмэгдлийг давхардуулан илүү олгосон байна.                | 1           | 553.5    | 1             | 553.5 |                 |          |         |     |                                      |                     |   |     |
| Ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 80 хувиар тооцож илүү олгосон.     | 1           | 418.2    | 1             | 418.2 |                 |          |         |     |                                      |                     |   |     |
| ИТХ нь төсвийг зориулалт бусаар зарцуулсан                             | 1           | 895.4    |               |       | 1               | 895.4    |         |     |                                      |                     |   |     |
| Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан | 1           | 12,698.9 |               |       | 1               | 12,698.9 |         |     |                                      |                     |   |     |

|  |           |                 |          |              |          |                 |          |                 |  |  |  |  |
|--|-----------|-----------------|----------|--------------|----------|-----------------|----------|-----------------|--|--|--|--|
| Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулаагүй байна.   | 1         | 4,300.0         |          |              | 1        | 4,300.0         |          |                 |  |  |  |  |
| Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан.   | 1         | 26,153.7        |          |              | 1        | 26,153.7        |          |                 |  |  |  |  |
| ИТХ-нь тайлант жилд үндсэн хөрөнгийн бүртгэлд шинээр орлогод авсан 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын жилийг үндэслэлгүй тогтоож, бүртгэсэн байна.  | 1         | -               |          |              |          |                 | 1        | -               |  |  |  |  |
| ИТХ нь Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэж тавилга эд хогшлын дансанд 5 нэр төрлийн <b>964.0</b> мянган төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэсэн байна. | 1         | 964.0           |          |              |          |                 | 1        | 964.0           |  |  |  |  |
| Он дамжсан насжилт өндөртэй 2000 онд үүссэн итгэлийн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.  | 1         | 732.3           |          |              |          |                 | 1        | 732.3           |  |  |  |  |
| Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан.   | 1         | 9,163.5         |          |              |          |                 | 1        | 9,163.5         |  |  |  |  |
| <b>Дүн</b>   | <b>10</b> | <b>55,879.5</b> | <b>2</b> | <b>971.7</b> | <b>4</b> | <b>44,048.0</b> | <b>4</b> | <b>10,859.8</b> |  |  |  |  |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр  | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|   |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|   | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b> |             |     |               |     |                 |     |         |     |
|   |             |     |               |     |                 |     |         |     |
|   |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Дүн</b>  |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>                 |             |     |               |     |                 |     |         |     |

|   |          |                 |  |  |  |  |          |                 |
|---|----------|-----------------|--|--|--|--|----------|-----------------|
| ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэх байгууллагатай гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулаагүй санхүүжилтийн 30 хувийг урьдчилж олгосон. | 1        | 9,827.4         |  |  |  |  | 1        | 9,827.4         |
| Хууль тогтоомжийн хэрэглээг буруу ашигласан, мөнгөн урамшуулал олгохтой холбоогүй заалтыг үндэслэсэн сумын ИТХ-ын тогтоолоор төлөөлөгчдөд урамшуулал олгох шийдвэр гаргасан байна.  | 1        | 4,480.0         |  |  |  |  | 1        | 4,480.0         |
| <b>Дүн</b>  | <b>2</b> | <b>14,307.4</b> |  |  |  |  | <b>2</b> | <b>14,307.4</b> |
| <b>Нийт дүн</b>   | <b>2</b> | <b>14,307.4</b> |  |  |  |  | <b>2</b> | <b>14,307.4</b> |